



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

608. Нийгмийн даатгалын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай 2285

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

609. Тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 47 2286

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

610. Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан
тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 183 2286

611. Шүүгчийн албан тушаалаас
огцруулах тухай Дугаар 184 2287

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

612. Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай Дугаар 71 2287

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын “хөдөлмөрийн” гэснийг “нийгмийн хамгааллын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Ц.Тогоохүүг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Л.Банзрагчийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Л.Борыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдсон тул Д.Оюунжаргалыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.3, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын 2012 оны 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хүний хөгжил сангаас хөрөнгө зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий 3.5, 3.6, 3.7 дахь хэсэг нэмсүгэй:

“3.5. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Хүний хөгжил сангаас хүүхдийн мөнгө олгох үйл ажиллагааг Монголбанктай байгуулсан гэрээний үндсэн дээр хамтран хэрэгжүүлнэ.

3.6. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монголбанкинд хүүхдийн мөнгөний тусгай дансыг нээлгэнэ. Монголбанк уг данснаас арилжааны банк дахь хүүхэд бүрийн дансанд мөнгө шилжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж, тайланг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.



3.7. Хүний хөгжил сангаас хүүхдийн мөнгө олгох үйл ажиллагааг Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журмаар нарийвчлан зохицуулна.”

2. Мөн журмын 3.3 дахь хэсгийн “Монголбанк дахь” гэсний өмнө “хүүхдийн мөнгөний санхүүжилтийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд,” гэж нэмсүгэй.

3. Мөн журмын 3.2 дахь заалтад “Сангийн яамны Төрийн сангийн газарт” гэснийг “санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад” гэж, 3.3 дахь заалтад “Сангийн яамны Төрийн сангийн газар” гэснийг “санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж, 4.2 дахь заалтад “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” гэснийг “Төсвийн тухай” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 0.25

Индекс: 14003